



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/107.

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4. "д" дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн орон нутгийн дулаан хангамжийн хэсэгтэй хамтран аймгийн хэмжээнд дулаан хангамжийн системд тохируулга, зүгшрүүлэг, тооцоо, судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Г.Лхагвабаатар	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
	Б.Мөнхгэрэл	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Д.Дарханбаяр	-“Хэнтий-Ус” ХХК-ийн Ерөнхий инженер
	Б.Мөнхбадам	-“Хэнтий-Ус” ХХК-ийн Дулааны инженер
Нарийн бичгийн дарга:	Д.Баттулга	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Аймгийн хэмжээнд дулаан хангамжийн системд тохируулга, зүгшрүүлэг, тооцоо, судалгаа хийхэд шаардлагатай мэдээ мэдээллээр хангах болон бусад чиглэлээр “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн орон нутгийн дулаан хангамжийн хэсэгтэй хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

